

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны ... дугаар  
сарын ...-ны өдөр

Улаанбаатар  
хот

### МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 37 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай дараах хэсэг нэмсүгэй:

1/ 37 дугаар зүйлийн 37.4 дэх хэсэг:

“37.4.Улсын Их Хурлын нийт гишүүдийн дөрөвний нэгээс доошгүй нь Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадаг байгууллагын эрх бүхий албан тушаалтныг үүрэгт ажлаа хангалтгүй биелүүлсэн гэж үзвэл огцруулах саналыг гаргах эрхтэй. Уул албан тушаалтныг огцруулахыг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн бол энэ тухай тогтоол баталсанд тооцно.”

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг батлагдсан өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.